

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020.10.21-ний өдрийн 08 дугаар хүралдааны шийдвэрээс:

8.1. “Ил, далд уурхайд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 125 дугаар тушаалын хавсралтаар батлуулахаар шийдвэрлэв.

8.2. “Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ын төслийг шинэчлэн батлуулах тухай хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулан, ТОНОББ-уудад сурталчилах, таниулах ажлыг зохион байгуулахыг даалгав.

8.3. “Радио холбоо зохион байгуулах журам”-ын төслийн тухай хэлэлцээд батлав.

8.4. “Гал түймрийн улсын хяналтын хуудас” батлах тухай хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

8.5. “ОБЕГ-ын харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах аргачлал, заавар”-ын төслийн тухай хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулан ТОНОББ-уудад хүргүүлэхийг даалгав.

8.6. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ОББ-аас хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.7. ОБЕГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд III улирлын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 87,4 хувьтай батлав.

---oOo---